



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (577)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2009 оны нэгдүгээр сарын 28

№4 (577)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

49.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	51
50.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	51
51.	Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	52
52.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	52
53.	Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	52
54.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	53
55.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	53
56.	Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	53
57.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	54
58.	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	54
59.	Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	55
60.	Иргэний бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	55
61.	Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	56
62.	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	56
63.	Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	57
64.	Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	57
65.	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	58
66.	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	58
67.	Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	59
68.	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	59
69.	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	60
70.	Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	60
71.	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	61
72.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	61

73.	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	62
74.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	62
75.	Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	62
76.	Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	62
77.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	63
78.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	64
79.	Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай	64
80.	Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	65
81.	Иргэний нисэхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	65
82.	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	65
83.	Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай	66
84.	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	66
85.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	66
86.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	67
87.	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	67
88.	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	67
89.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	68
90.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	68
91.	Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	68
92.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	69

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

93.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүүдүүвчийг батлах тухай	Дугаар 43	69
94.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 44	70
95.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 45	70

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

96.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 404	71
97.	Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай	Дугаар 405	71
98.	Зарим хүмүүсийг аймгийн захиргааны хэргийн болон, сум дунд, дүүргийн шүүхийн шүүгч, аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 406	71
99.	Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүнийг томилох тухай	Дугаар 407	72
100.	Дэндэвийн Пүрэвдоржид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 01	72
101.	Лодонгийн Түдэвт Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээх тухай	Дугаар 02	72

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "мэдээлэл, харилцаа холбоо, өндөр технологийн асуудал;" гэсний өмнө "-улсын хөгжлийн бодлого; -улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн бодлого; -хөрөнгө зруулалтын нэгдсэн бодлого; -улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хөгжлийн төлөвлөлт хийх, салбар хоорондын бодлогын уялдааг хангах асуудал; -эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг одорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;" гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын "-шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах" гэсний дараа ", хэрэглэгчдийн эрх шийг хамгаалах" гэж, мөн заалтад "-иргэн, уулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл," гэж, мөн хэсгийн 3 дахь заалтын "-адаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт" гэсний дараа ", бүртгэл" гэж тус тус эмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалтын "-бүртгэлийн нэгдсэн огтолцооны удирдлага;" гэснийг "-нягтлан бодох бүртгэлийн бодлого;" гэж, мөн хэсгийн 5 дахь

заалтын "-хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон төрийн бус байгууллагын бүртгэл;" гэснийг "-хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүртгэл;" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4 дэх заалтын "улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл," "-гадаадын хөрөнгө оруулалтын бүртгэл." гэснийг, мөн хэсгийн 5 дахь заалтын "иргэний болон иргэний гэр бүлийн бүртгэл, мэдээлэл," гэснийг, мөн хэсгийн 7 дахь заалтын "-үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн асуудал." гэснийг, мөн хэсгийн 10 дахь заалтын "-хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;" гэснийг, 27 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор" гэснийг, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын ", түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус" гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн зориулсугай:

"12.1.Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс ихүүжүүлнэ."

2 дугаар зүйл. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн "Улсын төсвөөс санхүүждэг агентлагийн" гэснийг "Агентлагийн" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-12.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын "улсын төсвөөс санхүүждэг Засгийн газрын агентлагийн удирдах ба гүйцэтгэх албан тушаал, үйл ажиллагааныхаа орлогоос санхүүждэг Засгийн газрын агентлагийн дарга" гэснийг "Засгийн газрын агентлагийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал" гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын "Цагдаагийн ерөнхий газрын дарга" гэснийг "цагдаагийн төв байгууллагын дарга" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын

"Засгийн газраас байгуулсан төрийн захиргааны бусад төсөвт байгууллагын болон" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 9¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"9¹ дүгээр зүйл. Үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

9¹.1. Үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхтэй:

9¹.1.1. эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулах;

9¹.1.2. төсвийн удирдлага, санхүүжилтийг

боловсронгүй болгох санал боловсруулан эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх."

2 дугаар зүйл. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийн "Сорьцын улсын хяналтын албаар" гэснийг "сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

008 оны 12 дугаар арын 19-ний өдөр

Улаанбаатар хот

АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ажиллах хүч гадаадад эргэх, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үхэй хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.7 дахь заалтын адаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх лбаны” гэснийг “гадаадын иргэн, харьяатын суудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” иж, мөн зүйлийн 8.5, 8.7 дахь хэсгийн “Гадаадын ргэн, харьяатын асуудал эрхлэх албанд” гэснийг адаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

008 оны 12 дугаар арын 19-ний өдөр

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Автотээврийн тухай хуульд эр дурдсан агуулгатай 6¹ дүгээр зүйл нэмсүгэй:

6¹ дүгээр зүйл. Автотээврийн асуудал эхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн иж

6^{1.1}. Автотээврийн асуудал эрхэлсэн ирийн захиргааны байгууллага дараахь бүрэн ихийг хэрэгжүүлнэ:

6^{1.1.1}. автотээврийн талаар төрөөс иримтлах бодлого болон хууль тогтоомжийн ргэжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, илэлтийг шалгах, дүнг мэдээлэх;

6^{1.1.2}. улс хоорондын зорчигч болон иаа тээвэр, нийтийн тээвэр, шуудан, жуулчин эвэрлэлтийн үйлчилгээ болон автотээврийн рэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх;

6^{1.1.3}. тээврийн хэрэгслийн ртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, лбогдох байгууллагыг байнгын мэдээллээр нгах;

6^{1.1.4}. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх;

6^{1.1.5}. хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “ хэрэгжүүлэх” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “төв” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

08 оны 12 дугаар арын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 17 дахь хэсгийн “Цагдаагийн ерөнхий газрын рга” гэснийг “цагдаагийн төв байгууллагын дарга” иж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн эгдаагийн ерөнхий газрын” гэснийг “цагдаагийн з байгууллагын” гэж, 16 дугаар зүйлийн 16.1, 16.3 6.5 дахь хэсгийн “Цагдаагийн ерөнхий газарт” инийг “цагдаагийн төв байгууллагад” гэж, мөн

зүйлийн 16.2, 16.4 дэх хэсгийн “Цагдаагийн ерөнхий газар” гэснийг “Цагдаагийн төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 17 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газарт" гэснийг "хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, мөн зүйлийн

4 дэх хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"11¹ дүгээр зүйл. Гадаадын иргэдийн иргэний гэр бүлийн байдлын бүртгэл"

1. Гадаадын иргэдийн иргэний гэр бүлийн байдлыг нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймагт аймгийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба эрхлэн явуулж, холбогдох мэдээллийг тухай бүр гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ."

2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Албаны" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 1, 3, 5, 7 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Албанд" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагад" гэж, 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Албанаас" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас" гэж, 26 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "албанд" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Алба" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт, 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дугаар зүйлийн 1 - 4 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Алба" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "(цаашид "Алба" гэх)" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ОРДНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Төрийн ордны хай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийн цагдаагийн ерөнхий газрын даргын" гэснийг алдааны төв байгууллагын даргын" гэж өөрчилсүгэй.

өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн тухай уулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг дор рдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.7. Иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн рийн захиргааны байгууллага болон аймаг, йслэлийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн ба нь улсын төсвөөс санхүүжэн."

2 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн тухай уулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 23 дугаар йлийн 23.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2 хь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн ргэний бүртгэл, мэдээллийн улсын төв" гэснийг ргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн хиргааны байгууллага" гэж, 16 дугаар зүйлийн .6 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн ргэний бүртгэл, мэдээллийн улсын төв" гэснийг ргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн хиргааны байгууллага" гэж, 6 дугаар зүйлийн 6.3 хь хэсгийн "Засаг даргын дэргэдэх Иргэний ртгэл, мэдээллийн алба" гэснийг "иргэний ртгэлийн асуудал эрхэлсэн алба" гэж, мөн йлийн 6.4 дэх хэсгийн "Засаг даргын дэргэдэх гэний бүртгэл мэдээллийн албанд", 16 дугаар йлийн 16.3 дахь хэсгийн "Засаг даргын дэргэдэх гэний бүртгэл мэдээллийн албанд" гэснийг гэний бүртгэлийн асуудал эрхэлсэн албанд" гэж, угаар зүйлийн 6.3, 6.6 дахь хэсэг, 14 дүгээр йийн 14.7 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 ь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийн гэний бүртгэл, мэдээллийн улсын төвд" гэснийг гэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн ргааны байгууллагад" гэж, 6 дугаар зүйлийн 6.8 ь хэсгийн "Аймаг, нийслэл, дүүргийн Иргэний гтгэл, мэдээллийн албаны даргын" гэснийг

"Аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба болон дүүргийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн нэгжийн даргын" гэж, 7 дугаар зүйлийн гарчгийг "Иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг" гэж, мөн зүйлийн 7.1 дэх хэсгийн "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв" гэснийг "Иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн "Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба" гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 29 дүгээр зүйлийн 29.5, 29.7 дахь хэсгийн "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас" гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн "Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвд " гэснийг "Иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг:

"7. Нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт аймгийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба гадаадад хувийн хэргээр зорчих иргэний үндэсний гадаад паспорт авах хүсэлтийг 10 хоног, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цагаачлах хүсэлтийг 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

8. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр иргэний гадаадад хувийн хэргээр зорчих эрхийг түдгэлзүүлсэн тохиолдолд нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт аймгийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн тохиолдолд гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үндэслэл бүхий хариуг бичгээр өгнө."

2/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Монгол Улсын үндэсний гадаад паспортыг нийслэлд иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны байгууллага, орон нутагт аймгийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба, гадаадад дипломат төлөөлөгчийн болон консулын газар олгоно."

2 дугаар зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний бүртгэл, мэдээлийн улсын төв" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, мөн зүйлийн 10 дахь хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэснийг "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба нь Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлэх бөгөөд уг төв нь" гэснийг "аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба нь иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд уг төрийн захиргааны байгууллага нь" гэж, мөн зүйлийн 20.11 дэх хэсгийн "Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба" гэснийг "Аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн

асуудал эрхэлсэн алба" гэж, мөн зүйлийн 20.12 дахь хэсгийн "аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албаны даргыг" гэснийг "аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн албаны даргыг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

008 оны 12 дугаар
арын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ИПОТЕКИЙН ЗҮЙЛИЙГ ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ХУДАЛДАН БОРЛУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ипотекийн зүйлийг шүүхийн ус журмаар худалдан борлуулах журмын тухай гуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын "Эд эрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд эрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн алба / зашид "Эрхийн улсын бүртгэлийн алба" гэх/нд" гэснийг "эрхийн улсын бүртгэлийн асуудал эхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 24.1, 24.4 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн "Эрхийн улсын бүртгэлийн тбанд" гэснийг "эрхийн улсын бүртгэлийн асуудал эхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсэг, 11 дүгээр

зүйлийн 11.3 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн "Эрхийн улсын бүртгэлийн алба" гэснийг "Эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн "Эрхийн улсын бүртгэлийн алба" гэснийг "эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

008 оны 12 дугаар
арын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ХАРЬАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын адаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эхэлсэн төрийн захиргааны байгууллагаас" гэж, 2 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 4, 6 дахь хэсэг, 1 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаар" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар" гэж, 20 дугаар зүйлийн 3, 5 дахь

хэсгийн "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, мөн зүйлийн 3, 6 дахь хэсгийн "иргэний бүртгэл, мэдээллийн алба" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба" гэж, 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба" гэснийг "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлэх бөгөөд тус төв" гэснийг "иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх бөгөөд тус байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6.1.9-6.1.13 дахь заалт нэмсүгэй:

“6.1.9. төрийн өмчийн үндсэн сүлжээний тогтвортой ажиллагааг хангах, хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх техник, технологи, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөж гүйцэтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах;

6.1.10. төрийн өмчийн үндсэн сүлжээг өргөтгөн хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжүүлэх, холбогдох тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх;

6.1.11. төрийн өмчийн үндсэн сүлжээний хөрөнгө оруулалтыг зохион байгуулах, сүлжээ ашиглалтын гэрээг үйлчлэгчтэй байгуулах;

6.1.12. бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хөрөнгө төвлөрүүлэн зориулалтын дагуу зарцуулах, биелэлтийг Ерөнхий сайдад тайлагнах;

6.1.13. харилцаа холбооны талаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, холбогдох байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;”

2 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчгийг “Харилцаа

холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх” гэж, мөн зүйлийн 6.1 дэх хэсгийн “Шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, мөн зүйлийн 6.2 дахь хэсгийн “шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй” гэснийг “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай” гэж, мөн зүйлийн 6.1.9 дэх заалтын дугаарыг “6.1.14” болгон тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “шуудангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 10 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.1. нөхөрлөл, компани, хоршоо, төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, холбоо, сан, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний орон нутаг дахь салбар;”

2 дугаар зүйл. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар
арын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай
улийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь
талтын "Гадаадын иргэн, харьяатын асуудал
хэлсэн албанд" гэснийг "гадаадын иргэн,
арьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны
йгууллагад" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан
дрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний
дрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар
арын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цацрагийн хамгаалалт,
зүлгүй байдлын тухай хуульд дор дурдсан
улгатай 5^д дүгээр зүйл нэмсүгэй:

**"5^д дүгээр зүйл.Цөмийн энергийн
асуудал эрхэлсэн төрийн захиргааны
байгууллага**

5^д.1. Цөмийн судалгаа, технологийг
гжүүлэх, цацрагийн үүсгүүр, цөмийн эрчим хүч
илгах, цөмийн болон цацрагийн хамгаалалт,
зүлгүй байдлыг хангах, мэргэжлийн хяналт тавих
г үүргийг цөмийн энергийн асуудал эрхэлсэн
ийн захиргааны байгууллага /цаашид "төрийн
иргааны байгууллага" гэх/ хэрэгжүүлнэ.

5^д.2. Төрийн захиргааны байгууллага нь
мийн материал, цөмийн болон ашиглагдахгүй
лсон цацраг идэвхт хаягдлыг улсын хэмжээнд
злөрүүлэн хадгалах, тээвэрлэх, булшлах тусгай
йгууламжтай байна.

5^д.3. Тусгай байгууламж нь улсын онцгой
ект байна."

2 дугаар зүйл.Цацрагийн хамгаалалт,
зүлгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн
дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн
руулсүгэй:

"5.1.Улсын хэмжээнд цөмийн энерги
илгах, цөмийн судалгаа, технологийг хөгжүүлэх,
рагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах
злого боловсруулах, цацраг идэвхт ашигт
пмал ашиглах үйл ажиллагааг холбогдох
йгууллагатай хамтран зохицуулах чиг үүрэг бүхий
н тооны бус Цөмийн энергийн комисс /цаашид
мисс" гэх/ ажиллана."

3 дугаар зүйл. Цацрагийн хамгаалалт,
зүлгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн
нгийн "Комиссын" гэснийг "Төрийн захиргааны
гууллагын" гэж, мөн зүйлийн 6.1 дэх хэсгийн
мисс" гэснийг "Төрийн захиргааны байгууллага"
11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, 12 дугаар

зүйлийн 12.1.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2,
18.1.6 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2
хь заалт, 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь хэсэг,
26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн "Комисс"
гэснийг "төрийн захиргааны байгууллага" гэж, 9
дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн
18.1.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг,
26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, 27 дугаар
зүйлийн 27.4.1 дэх заалтын "Комисст" гэснийг
"төрийн захиргааны байгууллагад" гэж, 9 дүгээр
зүйлийн 9.1.8 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.5
дахь заалтын "Комиссоор" гэснийг "төрийн
захиргааны байгууллагаар" гэж, 9 дүгээр зүйлийн
9.1.3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх
заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.2 дахь заалт,
16 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, 19 дүгээр
зүйлийн 19.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь
хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, 27 дугаар
зүйлийн 27.4.4 дэх заалтын "Комиссын" гэснийг
"төрийн захиргааны байгууллагын" гэж, 15 дугаар
зүйлийн 15.1.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.1.1
дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18
дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн
24.1 дэх хэсгийн "Комиссоос" гэснийг "төрийн
захиргааны байгууллагаас" гэж, 8 дугаар зүйлийн
8.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь
заалтын "5.6-д" гэснийг "5.1.2-т" гэж тус тус
өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Цацрагийн хамгаалалт,
аюулгүй байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн
5.6 – 5.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд
тооцсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан
дрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний
дрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Стандартчилал, хэмжил зүйн төвийн" гэснийг "стандартчиллын төв байгууллагын" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын тухай хуульд дор дурдсан агуулгатай 13¹ дүгээр зүйл нэмсүгэй:
"13¹ дүгээр зүйл. Соёл, урлагийн хороо

8/соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, тусалцаа үзүүлэх;

1.Төрөөс баримтлах соёл, урлагийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэгтэй Соёл, урлагийн хороо /цаашид "Хороо" гэх/ ажиллана.

9/соёлын тоо бүртгэл гаргаж, дүн шинжилгээ хийх;

2.Хорооны дүрмийг Засгийн газар батална.
3.Хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10/хуульд заасан бусад бүрэн эрх.

1/түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

4.Хороо нь дарга болон орон тооны бус 8 гишүүнээс бүрдэх бөгөөд Хорооны гишүүн нь улсын чанартай соёлын байгууллагын дарга, захирал байна.

2/эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан-гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

5.Хорооны дарга болон гишүүнийг соёл, урлагийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

3/түүх, соёлын дурсгалт зүйлийг судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, ашиглалт, хамгаалалтад хяналт тавих ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гадаад, дотоодод үзэсгэлэн гаргах ажлыг зохион байгуулах;

6.Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

4/утга соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалах, өвлүүлэх, судалж сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, утга соёлын өвийг өвлөн тээгч билиг авьяастнуудыг судлан тодорхойлж, эрдэм авьяасыг нь хойч үед уламжлуулахад туслан дэмжлэг үзүүлэх;

7.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд сард хоёроос доошгүй удаа хуралдана. Хуралдааны дэгийг Хорооны дүрмээр зохицуулна."

5/ардын язгуур урлагийн чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн "төрийн захиргааны төв байгууллага," гэсний дараа "Соёл, урлагийн хороо," гэж нэмсүгэй.

6/дүрслэх урлаг, дизайны чиглэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

3 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 8 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

7/соёлын салбарын боловсон хүчний эрэлт хэрэгцээг судалж, аймаг, нийслэлийн соёл, урлагийн байгууллагыг боловсон хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх;

"1.Соёлын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэнэ."

4 дүгээр зүйл. Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 5 - 7, 11, 13 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 22 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 22.2.9 дэх заалт нэмсүгэй:

"22.2.9. үнэт металлын сорьц тогтоох, эрдэнийн чулууны чанарын улсын хяналт тавих."

2 дугаар зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн "Стандартчилал, хэмжил зүйн төвийн"

гэснийг "стандартчиллын төв байгууллагын" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 16.1.4 – 16.1.7 дахь заалт нэмсүгэй:

"16.1.4. хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулж болзошгүй бараа үйлдвэрлэсэн, ажил, үйлчилгээ борлуулсан хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, уг барааны борлуулалт, үйлдвэрлэлтийг зогсоох тухай үндэслэл бүхий саналаа холбогдох эрх бүхий байгууллагад тавих;

16.1.5. барааны чанарыг дээшлүүлэх, бараандаа тохирлын баталгаа авахыг шаардах;

16.1.6. барааны чанар, аюулгүй байдалд итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;

16.1.7. хэрэглэгчийн эрхийг ноцтой хохироосон тухай үндэслэл бүхий албан ёсны шаардлага хүлээн авсан боловч арга хэмжээ аваагүй албан тушаалтанд зохих арга хэмжээ ногдуулах тухай саналыг холбогдох хяналтын байгууллагад тавих буюу шүүхэд нэхэмжлэл гаргах.

2 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын "хэрэглэгчийн" гэснийг өмнө "тухайн нутаг дэвсгэрт" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтын "бодлогыг хэрэгжүүлэх" гэснийг "бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг шалгах, дүнг мэдээлэх" гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн гарчиг болон 16.1 дэх хэсгийн "төв" гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 -19.1.3, 19.1.5, 19.1.7, 19.1.8 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5.4 дэх хэсэг нэмсүгэй:

"5.4. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.4.1. сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа хийх;

5.4.2. сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээний стандартыг боловсруулж, зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих."

2 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн дугаарыг "5.5, 5.6" болгон тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Цагдаагийн ерөнхий газартай" гэснийг "цагдаагийн төв байгууллагатай" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан

өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалтын "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын алба" гэснийг "иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн алба" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"12.1. Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "Хянан зохицуулах алба" гэх/



нь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг нь шалган дүнг мэдээлэх чиг үүрэг болон энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна."

2 дугаар зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн "чиг үүргийнхээ дагуу" гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 7¹ дүгээр зүйл нэмсүгэй:

7¹ дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл

7^{1.1} Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

7^{1.2} Малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, худалдах, импортлох тусгай зөвшөөрлийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно."

2 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "зөвшөөрөл" гэсний өмнө "тусгай" гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "холбогдох" гэсний дараа "төв" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "харилцаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12-21 зүгээр зүйлд зааснаар зохицуулагдана" гэснийг "харилцааг Эрүүл мэндийн тухай хуулиар юмхицуулна" гэж, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай"

гэснийг "энэ хуулийн 7¹ дүгээр зүйлд заасан байгууллагатай" гэж, мөн зүйлийн 8.6 дахь хэсгийн "Импортын зөвшөөрлийн бичигт" гэснийг "Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлд" гэж, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн "төрийн захиргааны холбогдох төв" гэснийг "эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 16¹ дүгээр зүйлийн 16^{1.3} дахь хэсгийн "Энэ хуулийн 16^{1.2}-т заасан" гэснийг "Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, худалдах" гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн "төрийн захиргааны холбогдох төв байгууллагын" гэснийг "эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 16¹ дүгээр зүйлийн 16^{1.2} дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 8¹ дүгээр зүйл нэмсүгэй:

8¹.1.9.хуульд заасан бусад бүрэн

"8¹ дүгээр зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

8¹.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8¹.1.1. эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

8¹.1.2. эрүүл мэндийг хамгаалах, дэмжих асуудлаар төрийн захиргааны бусад төв байгууллага, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх журмын биелэлтийг хангуулах;

8¹.1.3. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үйлдвэрлэлийн стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах;

8¹.1.4. эрүүл мэндийн магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

8¹.1.5. хөдөлмөрийн норм, нормативын хэрэгжилтийг зохион байгуулах;

8¹.1.6. эрүүл мэндийн статистик мэдээллийг гаргаж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах;

8¹.1.7. эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын сургалт зохион байгуулах, судалгаа тайлан гаргах;

8¹.1.8. хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх;

эрх."

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "төрийн захиргааны төв байгууллага," гэсний дараа "эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"8.1.3. хөдөлмөрийн норм, нормативыг ажилтны эрх, ашиг сонирхлыг төлөөлөх байгууллагын саналыг харгалзан төрийн захиргааны холбогдох төв байгууллагатай хамтран батлах."

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын "баталж, биелэлтийг хангуулах" гэснийг "батлах" гэж өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 22 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, 44¹ дүгээр зүйлийн 44¹.1 дэх хэсгийн "төв" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуульд дор дурдсан агуулгатай 6¹ дүгээр зүйл нэмсүгэй:

"6¹ дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

6¹.1. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6¹.1.1. эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаархи төрийн бодлого боловсруулахад шаардагдах тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх;

6¹.1.2. эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

6¹.1.3. эрчим хүчний шинэ эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

6¹.1.4. уламжлалт бус эрчим хүчний эх үүсвэрийн талаар судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах;

6¹.1.5. эрчим хүчний алдагдлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулах."

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "Сорьцын асуудал хариуцсан улсын хяналтын албаар" гэснийг "сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар" гэж, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Цагдаагийн ерөнхий газрын дарга" гэснийг "цагдаагийн төв байгууллагын дарга" гэж, 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Цагдаагийн ерөнхий газар" гэснийг

"цагдаагийн төв байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.19 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн "Иргэний нисэхийн ерөнхий газраас" гэснийг "иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас" гэж, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, мөн зүйлийн 8.4.6 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн "Иргэний нисэхийн ерөнхий газрын" гэснийг "иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн "арчгийн "Иргэний нисэхийн ерөнхий газрын" гэснийг "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийн "Иргэний нисэхийн ерөнхий газарт" гэснийг "иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллагад" гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 39^д дугаар зүйлийн 39^д.1 дэх хэсгийн "Иргэний нисэхийн ерөнхий газар" гэснийг "иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 8 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 8.1, 8.2, 8.4 - 8.6 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, 39^д дүгээр зүйлийн 39^д.1 дэх хэсэг, 39^д дугаар зүйлийн 39^д.1 дэх хэсгийн "Иргэний нисэхийн ерөнхий газар" гэснийг "Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсгийн "Иргэний нисэхийн ерөнхий газартай" гэснийг "иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газрын дарга" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Татварын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, мөн зүйлийн 19.2, 19.3 дахь хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2, 27.4 дэх хэсэг, мөн зүйлийн 27.6.8 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6, 47.8 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий

газрын" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж, 27 дугаар зүйлийн 27.5, 27.6 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газрын" гэснийг "Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газарт" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газрын дарга" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагын дарга" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

АГНУУРЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, АН АМЬТАН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалтын "Улсын татварын ерөнхий газарт" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, мөн хэсгийн 4 дэх заалт, мөн зүйлийн 7 дахь хэсгийн "Улсын татварын ерөнхий газар" гэснийг "татварын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

УС, РАШААНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалтын "Улсын татварын ерөнхий газарт" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн "Улсын татварын ерөнхий газар" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн "Үндэсний татварын ерөнхий газрын" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын" гэж, мөн зүйлийн 6.12 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтын "Үндэсний татварын ерөнхий газар" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага" гэж, мөн зүйлийн 15.1.2, 15.1.3 дахь

заалтын "Үндэсний татварын ерөнхий газарт" гэснийг "татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 11.4 дэх хэсгийн "импортлосон болон

үйлдвэрлэсэн" гэсний дараа "борлуулсан" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 1, 2, 3 дахь заалт:

Д/д	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр /		
		Автобензин тодорхойлсон октаны хэмжээ/ 90 хүртэл	/шинжилгээний аргаар 90 ба түүнээс дээш	Дизелийн түлш
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуун сухайт, Шивээ хүрэн, Баян хошуу, Бичигт, Хавирга	0-215.000	0-217.000	0-221.000
2	Ханх, Ульхан майхан	0-223.000	0-229.000	0-226.000
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрээнцав, Алтанбулаг	0-252.000	0-259.000	0-265.000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2007 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Москва хотноо байгуулсан "Монгол-Оросын "Монголросцветмет" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны

Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай суулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай" Улсын

Их Хурлын 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 43 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТООЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Ерөнхий сайдын эрхлэх ажлын үндсэн хүрээнд	1. Тагнуулын ерөнхий газар 2. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо 3. Цөмийн энергийн газар 4. Төрийн өмчийн хороо 5. Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газар	
Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	6. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7. Стандартчилал, хэмжил зүйн газар	1. Оюуны өмчийн газар 2. Улсын бүртгэлийн ерөнхий газар
Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 9. Онцгой байдлын ерөнхий газар	3. Хүүхдийн төлөө газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		4. Удирдлагын академи 5. Төр, засгийн үйлчилгээ, аж ахуй эрхлэх газар
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		6. Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар 7. Гадаадын хөрөнгө оруулалтын газар
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		8. Гаалийн ерөнхий газар 9. Татварын ерөнхий газар
Сууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10. Цагдаагийн ерөнхий газар 11. Хил хамгаалах ерөнхий газар	10. Архивын ерөнхий газар 11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 12. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар
Зайгаль орчин, аялал куулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		13. Ойн газар 14. Усны газар 15. Цаг уур, орчны шинжилгээний газар
атлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	12. Зэвсэгт хүчний Жанжин штаб	
оловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		16. Соёл, урлагийн хороо



Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	17. Иргэний нисэхийн ерөнхий газар 18. Төмөр замын газар 19. Автотээврийн газар 20. Авто замын газар 21. Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	22. Нийгмийн даатгалын ерөнхий газар 23. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд	24. Жижиг, дунд үйлдвэрийн газар 25. Мал эмнэлэг, үржлийн газар 26. Ашигт малтмалын газар 27. Газрын тосны газар 28. Эрчим хүчний газар 29. Биеийн тамир, спортын газар 30. Эрүүл мэндийн газар
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Дүрэм батлах тухай" Улсын Их Хурлын 2002 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 71 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын консулын дүрэм"-ийн Аравын 2 дахь заалтын "Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх

албанд" гэснийг "гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад" гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 48 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр"-ийн 3.2.5.8-ын 3 дахь заалтын "Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс" гэснийг "стандартчиллын төв байгууллагаас" гэж, 3.2.5.15-ын "Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв" гэснийг

"стандартчиллын төв байгууллага" гэж, хоёрдугаар хавсралтаар баталсан "Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 7.1.11, 7.1.14, 7.1.19 дэх заалтын "СХЗҮТ" гэснийг "стандартчиллын төв байгууллага" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь буюу 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.4 дэх заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн өөрөө хүсэлт гаргасан Доржсүрэнгийн Батбаясгаланг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Жанчивын Энхжаргалыг

Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул Баянжавын Сумъяаг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.5, 78 дугаар зүйлийн 78.4 дэх заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр

шүүхийн шүүгч Базарсадын Нацагдоржийг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг аймгийн захиргааны хэргийн болон сум дунд, дүүргийн шүүхийн шүүгч, аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.6 дахь заалтыг ус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Энхжаргалын Золбадрахыг Говь-Алтай аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Лувсангийн Эрдэнэбатыг Хөвсгөл аймаг дахь сум

дундын шүүхийн шүүгчийн, Чулуунбаатарын Отгонбаярыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд, Цэрэннадмидын Батсүрэнг Дорнод аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүнийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн Даваажавын Батсайханыг Улсын

дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүнээ томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Дэндэвийн Пүрэвдоржид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Утга зохиол, урлагийн салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж дууны шүлэг, яруу найргийн болон үргэлжилсэн үгийн шилдэг бүтээлүүд туурвиж, Монголын утга зохиолд яруу найргийн төрөл зүйлийг хөгжүүлэх, шинэ үеийн утга зохиолын түүхэнд авъяас билэгт зохиолчдыг сургаж бэлтгэх, Монголын зохиолчдын эвлэлийн байгууллагыг удирдан зохион байгуулж,

бэхжүүлэхэд оруулсан жинтэй хувь нэмрийг н үнэлж зохиолч, яруу найрагч Дэндэвийн Пүрэвдоржид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одоо "Алтан соёмбо" тэмдгээр шагнаасугай!

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Лодонгийн Түдэвт Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээх тухай

Утга зохиол, хэвлэл мэдээлэл, нийгэм соёлын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, "Уулын үер", "Хорвоотой танилцсан түүх", "Нүүдэл суудал" зэрэг роман, тууж, өгүүллэг, яруу найраг, нийтлэлийн олон арван шилдэг бүтээл туурвин, "Бүтээлийн чуулган" 30 боть номоо уншигч түмэндээ толилуулж, Монголын утга зохиолын сан

хөмрөгийг баяжуулахад оруулсан үнэтэй ху нэмрийг нь үнэлж "Дал" сонин эрхлэгч, зохиол доктор Лодонгийн Түдэвт Монгол Улсын ардын ур зохиолч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 262420
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 3